



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/462

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Магадлан итгэмжлэлийн хугацаа тасарч сунгагдаж буй эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэл эхлэх хугацааг 2022 оны 9 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн тооцсугай.
3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 18 дугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141222190

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09 дугаар сарын 12 ны өдрийн А/462 дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Сүхбаатар дүүрэг, Энхийн санаа өрхийн эрүүл мэндийн төв	323/2022	3 жил	2022.09.13	2025.09.13
2.	Дундговь аймаг, Өлзийт мандал өрхийн эрүүл мэндийн төв	324/2022	3 жил	2022.09.13	2025.09.13
3.	Дундговь аймаг, Адаацаг сумын эрүүл мэндийн төв	325/2022	3 жил	2022.10.30	2025.10.30
4.	Дундговь аймаг, Баянжаргалан сумын эрүүл мэндийн төв	326/2022	3 жил	2022.10.30	2025.10.30
5.	Өмнөговь аймаг, Өнө-Орших өрхийн эрүүл мэндийн төв	327/2022	3 жил	2022.11.01	2025.11.01
6.	Өмнөговь аймаг, Шимбилэг өрхийн эрүүл мэндийн төв	328/2022	2 жил	2022.11.30	2024.11.30
7.	Өмнөговь аймаг, Хүрмэн сумын эрүүл мэндийн төв	329/2022	2 жил	2022.10.27	2024.10.27
8.	Өмнөговь аймаг, Хатан заяат говь ХХК-ийн эмнэлэг	330/2022	4 жил	2022.09.13	2026.09.13
9.	Өвөрхангай аймаг, Хайрхандулаан сумын эрүүл мэндийн төв	331/2022	2 жил	2022.09.09	2024.09.09
10.	Сүхбаатар аймаг, Энхлэн-Ачтан өрхийн эрүүл мэндийн төв	332/2022	2 жил	2022.09.09	2024.09.09
11.	Сүхбаатар аймаг, Энэрэлт-Ачтан өрхийн эрүүл мэндийн төв	333/2022	2 жил	2022.09.09	2024.09.09
12.	Сүхбаатар аймаг, Наран сумын эрүүл мэндийн төв	334/2022	2 жил	2022.09.09	2024.09.09
13.	Сүхбаатар аймаг, Мижарис эмнэлэг	335/2022	3 жил	2022.09.09	2025.09.09
14.	Хөвсгөл аймаг, Галт халуун рашаан ХХК-ийн сувилал	336/2022	3 жил	2022.09.13	2025.09.13